

# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДААТГАЛЫН ГАЗАР

## ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН 2009 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН САНХҮҮ, ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА

### ТАНИЛЦСАН:

ХОРООНЫ ДАРГА  
ХОРООНЫ ГИШҮҮН  
ХОРООНЫ ГИШҮҮН  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

Д. БАЯРСАЙХАН  
Б. ШАРАВСАМБУУ  
Д. ДҮГЭРЖАВ  
Х.БУМ-ЭРДЭНЭ

### ХЯНАСАН:

ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА  
ДААТГАЛЫН ГАЗРЫН ОРЛОГЧ ДАРГА

С. ГАНБОЛД  
П. ЦЭРЭНДЭЖИД

### БОЛОВСРУУЛСАН:

ДААТГАЛЫН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН

Б. ОЮУНТУЯА

УЛААНБААТАР ХОТ  
2009 ОН


## ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН 2009 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН САНХҮҮ, ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА

2009 оны 3 дугаар улирлын байдлаар Хорооноос даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан ердийн даатгалын 15, ердийн даатгалын компанийн салбар 130, урт хугацааны даатгалын 1, давхар даатгалын 1, даатгалын зуучлагч 4 компани болон даатгалын төлөөлөгч 1639 иргэн, нийт 1790 иргэн, хуулийн этгээд даатгалын зах зээлд оролцож үйл ажиллагаа явуулсан байна.

### I. ХӨРӨНГӨ

Энэ оны 3 дугаар улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй 17 компанийн хөрөнгийн нийт хэмжээ 39.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.2 тэрбум төгрөг буюу 11.9 хувиар, өмнөх оны эцсээс 4.9 тэрбум төгрөгөөр буюу 14.3 хувиар тус тус өссөн байна (Зураг-1).

Зураг-1



2008 оны 3 дугаар улиралд системийн дүнгээр нийт эргэлтийн хөрөнгө 30.3 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 86.5 хувь, эргэлтийн бус хөрөнгө нь 4.7 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 13,5 хувийг эзэлж байсан бол 2009 оны 3 дугаар улиралд эргэлтийн хөрөнгө 34.7 тэрбум төгрөгт хүрч нийт хөрөнгийн 88.5 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 2.0 пунктээр өсч хөрөнгийн бүтцэд бага зэрэг өөрчлөлт гарсан байна (Хүснэгт-1).

Хүснэгт-1

#### Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө

(сая төг)

Үзүүлэлтүүд	2008-III		2009-III		өсөлт/бууралт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Эргэлтийн хөрөнгө	30 308.9	86.5	34 696.3	88.5	4 387.4	114.5
Эргэлтийн бус хөрөнгө	4 728.0	13.5	4 511.6	11.5	-216.4	95.4

<b>Нийт хөрөнгө</b>	<b>35 036.9</b>	<b>100.0</b>	<b>39 207.9</b>	<b>100.0</b>	<b>4 171.0</b>	<b>111.9</b>
---------------------	-----------------	--------------	-----------------	--------------	----------------	--------------

2009 оны 3 дугаар улирлын байдлаар эргэлтийн хөрөнгийн 75.9 хувийг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, 10.0 хувийг богино хугацаат хөрөнгө оруулалт, 6.8 хувийг дансны авлага, үлдэх 7.1 хувийг бусад эргэлтийн хөрөнгө эзэлж байна. Эргэлтийн хөрөнгийн бүтцийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эргэлтийн хөрөнгөнд эзлэх хувь 15.3 пунктээр огцом өссөн нь даатгалын компаниуд Хорооны 2006 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн дүрмийн сан болон нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага” журмыг дагаж мөрдөж ажиллах болсноор тайлбарлаж болохоор байна (Хүснэгт-2).

Хүснэгт-2

**Эргэлтийн хөрөнгө**

(сая төг)

Үзүүлэлтүүд	2008-III		2009-III		өсөлт/бууралт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	18 170.8	<b>60.0</b>	26 350.7	<b>75.9</b>	8 179.9	<b>145.0</b>
Богино хугацаат хөрөнгө оруулалт	6 519.3	21.5	3 480.8	10.0	-3 038.5	53.4
Дансны авлага	2 311.6	7.6	2 369.5	6.8	57.9	102.5
Бусад эргэлтийн хөрөнгө	3 307.2	10.9	2 495.3	7.2	-811.9	75.5
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>30 308.9</b>	<b>100.0</b>	<b>34 696.3</b>	<b>100.0</b>	<b>4 387.4</b>	<b>114.5</b>

Энэ оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудыг хөрөнгийн хэмжээгээр нь жагсаахад “Монгол даатгал” ХХК 13.2 тэрбум төгрөгийн хөрөнгөтэйгээр нийт даатгалын зах зээл дээрх хөрөнгийн 33.7 хувийг эзэлж байгаа бол “Болор-Итгэл даатгал” ХХК хамгийн бага буюу 0.5 тэрбум төгрөгийн хөрөнгөтэйгээр зах зээлийн нийт хөрөнгийн 1.4 хувийг эзэлж байна (Хүснэгт-3).

Даатгалын зах зээл дээрх нийт хөрөнгийн 51.0 хувийг ердөө 3 даатгалын компани (“Монгол даатгал”, “Бодь даатгал”, “Прайм женерал даатгал” ХХК)-ийн хөрөнгө бүрдүүлж байна.

Хүснэгт-3

**Нийт хөрөнгийн хэмжээ**


№	Компанийн нэр	Нийт хөрөнгө (сая төг)	Эзлэх хувь
1	Монгол даатгал	13 231.5	33.7
2	Бодь даатгал	3 932.1	10.0
3	Прайм женерал даатгал	2 832.3	7.2
4	Миг даатгал	2 739.6	7.0
5	Номин даатгал	2 149.7	5.5
6	Ард даатгал	2 018.6	5.1
7	Практикал даатгал	2 005.7	5.1

8	Түшиг даатгал	1 593.3	4.1
9	Улаанбаатар хотын даатгал	1 288.6	3.3
10	УБ даатгал	1 224.7	3.1
11	Монгол траст холдинг даатгал	1 179.3	3.0
12	Нэйшнл лайф даатгал*	1 107.9	2.8
13	Ган зам даатгал	1 004.9	2.6
14	Мөнх даатгал	923.8	2.4
15	Жонон даатгал	787.0	2.0
16	Нийслэл даатгал	659.1	1.7
17	Болор-Итгэл даатгал**	529.9	1.4
	<b>ДУН</b>	<b>39 207.9</b>	<b>100.0</b>

## II. ӨР ТӨЛБӨР, ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

2009 оны 3 дугаар улиралд нөөц сангийн хэмжээ 23.4 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеийнхээс 1.5 тэрбум төгрөгөөр буюу 6.8 хувиар өссөн байна. Нөөц сангийн хэмжээ өссөн хэдий ч нийт хөрөнгөнд эзлэх хувь хэмжээ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад буурсан байгаа нь хуримтлагдсан ашгийн хэмжээ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1.1 тэрбум төгрөг буюу 2.8 дахин өссөнтэй холбоотой байна (Зураг-2).

Зураг-2



Тайлант хугацаанд даатгалын салбарын хэмжээгээр 1696.3 сая төгрөгийн хуримтлагдсан ашигтай ажилласан бол энэ үзүүлэлт өнгөрсөн оны мөн үед 556.2 сая төгрөг байсан байна.

### Ш. ОРЛОГО, ЗАРДАЛ

Тайлант хугацаанд даатгалын салбар 17.5 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого олсноос 4.6 тэрбум төгрөг буюу 26.3 хувийг давхар даатгалын хураамжид, 0.1 тэрбум төгрөг буюу 0.6 хувийг буцаасан даатгалын хураамжид олгож 12.6 тэрбум төгрөгийн даатгалын цэвэр хураамжийн орлого олжээ.

“Миг даатгал” ХХК, “Прайм женерал даатгал” ХХК, “Практикал даатгал” ХХК, “Ард даатгал” ХХК, “УБ даатгал” ХХК, “Ган зам даатгал” ХХК, “Нэйшнл лайф даатгал” ХХК-иудын даатгалын нийт хураамжийн орлого бага зэрэг өсч бусад даатгалын компаниудын хураамжийн орлого буурснаас энэ оны 3 дугаар улирлын даатгалын нийт хураамжийн орлогын хэмжээг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0.2 тэрбум төгрөг 1.1 хувиар буурсан байна.

Орлогод тооцсон хураамжийн 30.2 хувийг даатгалын нөхөн төлбөрт, 16.4 хувийг учирч болзошгүй хохирлын нөөц сан бүрдүүлэхэд зарцуулсан байна.

2008 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар даатгалын салбар 1475.3 сая төгрөгийн ашиг (татвар төлөхийн өмнөх)-тай ажиллаж байсан бол энэ оны эхний хагас жилийн байдлаар 2854.6 сая төгрөгийн ашигтай ажиллаж 93.5 хувийн өсөлттэй байсан байна. Татвар төлөхийн өмнөх ашгийн хэмжээ үлэмж хэмжээгээр өсөх болсон гол шалтгаан нь ердийн даатгалын компаниуд бүгд ашигтай ажиллаж, ашгийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс өссөн байна.

2008, 2009 онд шинээр үүсгэн байгуулагдсан “Нэйшнл лайф даатгал” ХХК, “Болор-Итгэл даатгал” ХХК-иуд энэ оны 3 дугаар улирлын байдлаар алдагдалтай ажиллаж байна.

Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж байгаа 17 даатгалын компанийг 2009 оны 3 дугаар улиралд олсон даатгалын хураамжийн орлогоор нь жагсаахад “Монгол даатгал” ХХК 5.4 тэрбум төгрөг буюу нийт зах зээлийн 30.5 хувийг эзэлж хамгийн өндөр орлого олсон бол “Болор-Итгэл даатгал” ХХК хураамжийн орлогогүй байна (Хүснэгт-4). Даатгалын зах зээл дэх нийт хураамжийн орлогын 66.1 хувийг “Монгол даатгал” ХХК, “Миг даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК-иудын олсон хураамжийн орлого бүрдүүлж байна.

Хүснэгт-4

#### Даатгалын хураамжийн орлого

№	Компанийн нэр	Хураамжийн орлого (сая төг)	Эзлэх хувь
1	Монгол даатгал	5 390.3	30.8
2	Миг даатгал	4 127.4	23.6
3	Бодь даатгал	2 146.9	12.3
4	Прайм женерал даатгал	1 293.5	7.4
5	Практикал даатгал	1 151.5	6.6
6	Номин даатгал	1 066.4	6.1
7	Ард даатгал	800.8	4.6


8	Түшиг даатгал	566.1	3.2
9	УБ даатгал	200.3	1.1
10	Мөнх даатгал	194.7	1.1
11	Улаанбаатар хотын даатгал	165.7	0.9
12	Ган зам даатгал	143.1	0.8
13	Жонон даатгал	85.8	0.5
14	Нийслэл даатгал	75.7	0.4
15	Монгол траст холдинг даатгал	51.8	0.3
16	Нэйшнл лайф даатгал*	24.8	0.1
17	Болор-Итгэл даатгал**	0.0	0.0
	<b>ДҮН</b>	<b>17 484.8</b>	<b>100.0</b>

#### IV. ДААТГАЛЫН ХУРААМЖ, НӨХӨН ОЛГОВОР

Даатгалын салбарын хэмжээгээр 2009 оны 3 дугаар улиралд нийт 17.5 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого олсны 99.9 хувь буюу 17.5 тэрбум төгрөг нь ердийн даатгалын, 0.1 хувь буюу 24.8 сая төгрөг нь урт хугацааны даатгалын хураамжаас олсон байна. 2009 оны 1 дүгээр улирлаас ердийн даатгалын хэлбэрийг олон улсад хэрэглэгддэг хэлбэрт нийцүүлэн шинэ хэлбэрээр гаргах болсон. Энэ оны эхний хагас жилд “хөрөнгийн” даатгалын хураамжийн орлого хамгийн их буюу 4.8 тэрбум төгрөг болж тэргүүлсэн бол “газар тариалангийн” даатгалаар хамгийн бага буюу 1.3 сая төгрөгийн орлого олсон байна (Зураг-3).


Зураг-3

**Даатгалын хураамжийн орлого,**  
2009 оны 3 дугаар улирлын байдлаар, сая төгрөгөөр



Монгол улсын даатгалын зах зээлд урт хугацааны даатгалын компани 2008 оны 2 дугаар сард үүсгэн байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд энэ оны 3 дугаар улирлын байдлаар 24.8 сая төгрөгийн даатгалын хураамжийн орлоготой ажилласны 24.6 сая төгрөг нь “хугацаат амьдралын” даатгал, 0.2 сая төгрөг нь “хуримтлалын” даатгал хийснээр олсон байна (Зураг-4).

Зураг-4



2009 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нийт 3.8 тэрбум төгрөгийн даатгалын нөхөн төлбөр олгосноос 3.4 сая төгрөгийг урт хугацааны даатгалаар нөхөн төлбөр олгосон байна. Даатгалын нөхөн төлбөр олгосон байдлыг ердийн даатгалын шинэ хэлбэрээр авч үзэхэд “авто тээврийн хэрэгслийн” даатгалаар хамгийн өндөр буюу 1.9 тэрбум төгрөг буюу нийт нөхөн олговрын 80.7 хувь байсан бол “газар тариалангийн” даатгалаар нөхөн төлбөр олгогдоогүй байна (Зураг-5).

Зураг-5



Энэ оны 3 дугаар улирлын байдлаар олгосон нөхөн олговрын хэмжээг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад нийт нөхөн олговрын хэмжээ 11.8 хувиар буюу 0.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

## V. НӨХӨН ОЛГОВРЫН ТҮВШИН

Тайлант хугацаанд даатгалын хохирол нөхөлтийн түвшин даатгалын салбарын дүнгээр 29.9 хувь болж 2008 оны мөн үеэс 1.9 пунктээр буурсан байна (Зураг-6).

Зураг-6



Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудыг даатгалын хохирол нөхөлтийн түвшингээр харьцуулахад 2009 оны 3 дугаар улирлын байдлаар “Түшиг даатгал” ХХК хамгийн өндөр буюу 48.7 хувь байсан бол “Жонон даатгал” ХХК 0,0 хувьтай байсан байна (Хүснэгт-5).

Хүснэгт - 5

### Даатгалын хохирол нөхөлтийн түвшин

№	Даатгалын компаниудын нэрс	Нөхөн төлбөрийн түвшин хувиар
1	Түшиг даатгал	48.7
2	Ард даатгал	39.9
3	Прайм женерал даатгал	32.6
4	Монгол даатгал	31.9
5	Мөнх даатгал	31.8
6	Практикал даатгал	31.5
7	Улаанбаатар хотын даатгал	28.0
8	Миг даатгал	26.5
9	Бодь даатгал	25.8
10	Нийслэл даатгал	20.4
11	УБ даатгал	20.2
12	Нэйшнл лайф даатгал*	17.1
13	Номин даатгал	11.0
14	Монгол траст холдинг даатгал	2.8



15	Ган зам даатгал	1.8
16	Жонон даатгал	0.0
	<b>ДҮН</b>	<b>29.9</b>

## VI. ДАВХАР ДААТГАЛ

2008 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар ердийн даатгалын үйл ажиллагаа явуулж буй 8 компани даатгалын эрсдэлээ давхар даатгуулж 4621.1 сая төгрөгийн хураамж төлсөн нь өнгөрөгч оны мөн үетэй харьцуулахад 421.5 сая төгрөгөөр буюу 10.0 хувиар өссөн байна (Хүснэгт-6).

Хүснэгт-6

### Давхар даатгалын хураамж

(сая төг)

№	Компанийн нэр	2008-III		2009-III		Өсөлт/бууралт	
		тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
1.	Ард даатгал	17.7	0.4	135.9	2.9	118.2	7.7 дахин
2.	Бодь даатгал	3 069.0	73.1	1 096.5	23.7	- 1 972.5	35.7
3.	Прайм женерал даатгал	89.9	2.1	271.5	5.9	181.6	302.0
4.	Практикал даатгал	9.1	0.2	104.2	2.3	95.1	11.5 дахин
5.	Миг даатгал	377.8	9.0	2 509.2	54.3	2 131.4	6.6 дахин
6.	Монгол даатгал	574.6	13.7	443.3	9.6	- 131.3	77.1
7.	Номин даатгал	39.7	0.9	54.5	1.2	14.8	137.3
8.	Түшиг даатгал	21.7	0.5			- 21.7	
9.	Нэйшнл лайф даатгал		0.0	5.9	0.1	5.9	
	<b>ДҮН</b>	<b>4 199.6</b>	100.0	<b>4 621.1</b>	<b>100.0</b>	<b>421.5</b>	<b>110.0</b>

Өнгөрсөн оны мөн үед нийт давхар даатгалын хураамжид 73.1 хувийг эзэлж байсан “Бодь даатгал” ХХК-ийн давхар даатгалын хураамж 64.3 хувиар буурсан нь МИАТ ХХК-ийн иргэний агаарын хөлгийн даатгалыг 2009 оноос хийхгүй болж харин энэхүү даатгалыг “Миг даатгал” ХХК хийх болсонтой холбоотой.

## VII. ДҮГНЭЛТ

Энэ оны 3 дугаар улирлын байдлаар даатгалын салбарын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үеийн үзүүлэлтүүдтэй харьцуулахад огцом уналтууд ажиглагдаагүй ч 2008 оны дунд үеэс дэлхийн эдийн засаг тэр дундаа санхүүгийн сектор хүндрэлд орж, энэ нь Монгол улсын эдийн засагт 2008 оны сүүлч 2009 оны эхэн үеэс мэдрэгдэж эхэлсэн нь даатгалын секторт ч бага зэрэг ажиглагдлаа. Тухайлбал энэ оны 3 дугаар улирлын байдлаар даатгалын хураамжийн орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.2 тэрбум төгрөг буюу 1.1 хувиар буурсан байна.

Гэхдээ даатгалын салбарын татвар төлөхийн өмнөх нийт ашгийн хэмжээ 2008 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар 1475.3 сая төгрөгийн ашиг (татвар төлөхийн өмнөх)-тай ажиллаж байсан бол энэ оны эхний хагас жилийн байдлаар 2854.6 сая төгрөгийн ашигтай ажиллаж энэ салбар ашигтай ажилласан мэт харагдаж байгаа боловч даатгалын нөөцийн санг байгуулах наймтын системээр тооцсон “өмнөх оны орлогод тооцоогүй хураамж”-ийн хэмжээ өндөр байгаатай холбоотойг хэлэх хэрэгтэй.

Давхар даатгалын хураамжийн хувьд 2008 оны 3 дугаар улирлын байдлаар 2007 оны мөн үетэй харьцуулахад 4.3 хувиар өсч байсан бол 2009 оны 3 улирлын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.0 хувиар өссөн байна.

#### ДААТГАЛЫН ГАЗАР